

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХӨДӨӨ АЖ АХУЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

А.Даваасүрэн*

Товч утга: энэхүү өгүүлэлд Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хөдөө аж ахуйн салбарын бүтэц, түүний бодит өсөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, малын тоо толгойны динамик өсөлт, малчдын нийт хүн амд эзлэх хувийн жин, газар тариалангийн хөгжлийн хандлагыг хөндсөн байна.

Түлхүүр үгс: Монгол Улс, хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан, өсөлт, малын тоо, малчин, ургацын хэмжээ.

Английн эрдэмтэн Ричард Кантильон тодорхойлсноор: манай малчин ба түүний өрх байгаль цаг агаарын өөрчлөлтөөс учрах эрсдлээ өөрөө хариуцдаг, Францын судлаач Ж.Бодогийн тодорхойлсоноор өөрийн үйл ажиллагааны төлөө өөрөө хариуцлага хүлээхээс гадна мал маллах үйл ажиллагаагаа өөрөө төлөвлөж, хянаж, зохион байгуулж байна гэжээ. Английн эдийн засагч А.Смитын тодорхойлсны дагуу малчид нь өмчийн эзэн бөгөөд өөрийн бүхий л үйл ажиллагааг малынхаа тоо, ашиг шимийг өсгөхийн төлөө чиглүүлж эрсдлээ өөрөө хариуцаж байгаа аж ахуй эрхлэгч юм. Тэрээр хувийн өмчтөн бөгөөд түүний хувийн мал нь аж ахуй эрхлэх материаллаг үндэс болж байна.

Францын эрдэмтэн Ж.Б.Сэйгийн тодорхойлсноор малчинд юуны өмнө, бэлчээрийн газар, хөдөлмөр буюу малчны гэр бүлийн гишүүд ажиллах хүч нь болж, тэрээр өөрийн ухамсарт үйл ажиллагааны үр дүнд малынхаа түүхий эд махыг зарж борлуулж хөрөнгийн хуримтлалыг бий болгож байна. Түүнд газар, хөдөлмөр, хөрөнгө зэрэг үйлдвэрлэлийн факторууд байгаа бөгөөд Монгол улсын хуулинд заасан боловч төр засгаас малчдын орлогыг нэмэгдүүлэх тэдний амжиргааныг түвшинг дээшлүүлэхэд зориулж газрын төлбөрөөс чөлөөлөгдөж байна. Сүүлийн үед зарим малчдын малын тоо өсөөд тэдний өөрсдийн ажиллах хүч хүрэлцэхгүй болохоор хөлсний малчин авч ажиллуулж тэдэнд хөдөмөрийн хөлс төлж байна. Малчид өөрийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгийн захиран зарцуулах эрх нь тэдэнд чөлөөтэй байна. Хэрэв хөрөнгө мөнгөний хэрэгцээ гарахад малчид малаа барьцаалан банк санхүүгийн байгууллагаас зээл авах илүү их болж байна.

Түүнчлэн Сэйгийн үзэж байгаагаар манай малчид сүүлийн жилүүдэд мал маллах арга зүйн шалгарсан шинэлэг санааг бие биенээсээ дамжуулан суралцаж аж ахуй үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

АНУ-ын эрдэмтэн Йозеф Шумпетерийн тодорхойлсноор аж ахуй эрхлэгч нь шинийг бүтээгч гэсэн тодорхойлолтой тохирч байна. Тухайлбал, малчид

*А.Даваасүрэн—ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), профессор

малынхаа хариуллага, маллагаанд өмнө нь олон жилийн өмнө отор хийж маш хол нүүдэллэж малаа таргалуулж байсан бол одоо цагт энэ арга барил устаж үгүй болж өөрийн эзэмшлийн газрыг малын бэлчээтрээ жилийн 4 улиралд хувааритайгаар ашиглах болж байна. Түүнээс гадна Й.Шумпетерийн үзэж байгаагаар малчин аж ахуйтан хөрөнгөтөн бөгөөд өөрийн үйл ажиллагаанаас олж байгаа ашгаа өөртөө зарцуулахаас гадна шинийг санаачлагч болж байна. Энэ ашиг нь түүний ухамсарт үйл ажиллагааны үр дүнд бий болсон юм.

Оросын эрдэмтэн А.Петражицкий: аж ахуй эрхлэгч гэдэг нь хувиараа, биеэ дааж, өөрийн нэрийн өмнөөс эрсдлээ дааж, өөрөө өртөө хариуцлага хүлээж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа субъектийг хэлнэ гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолттой манай малчин хүний бүх шинж чанар тохирч байна гэж бид үзэж байна.

Оросын эрдэмтэн Петражицкий аж ахуй эрхлэгчийн мөн чанарыг тодорхойлохдоо дараах шинж чанаруудад анхаарлаа хандуулсан. Үүнд:

- Биеэ даасан, хэнээс ч хамааралгүй аж ахуй эрхэлж буй байдал
- Эдийн засгийн сонирхол. Аж ахуй эрхлэгчийн гол зорилго бол бүхий л боломжоорсо ашиг олоход чиглэгдэж байна.
- Аж ахуйн эрсдэл, хариуцлага.
- Өөрт байгаа нөөцийг бүрэн ашиглах чадвар, эрчимтэй үйл ажиллагаа.

Ийм учраас бид манай малчдыг аж ахуй эрхлэгч гэж тодорхойлох бүрэн үндэслэлтэй гэж үзэж байна. Тэд улсын бүртгэлийн тусгай гэрчилгээ зөвшөөрөл аваагүй боловч (авах ч шаардлагагүй) хуулиар зөвшөөрөгдсөн аж ахуй эрхэлж байна. Манай улсын малчдыг аж ахуй эрхлэгч гэж үзэх дараах үндэслэлүүд байна. Тухайбал тэд мал маллах ухамсарт үйл ажиллагааны үр дүнд ашиг олохын төлөө, өөрт байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсээ (газар, ажиллах хүч, хөрөнгө, зохион байгуулах) ашиглан өөрсдөө эрсдлээ даан, шинийг санаачлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хуучин арга барилаа устгах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг. Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Хүснэгт 1. Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын бодит өсөлтийн хэмжээ
(2005 оны үнээр тооцсон хувиар)

	Хөдөө аж ахуйн салбарын бодит өсөлтийн	Мал аж ауйн салбарын бодит өсөлт	Газар тариалангын салбарын бодит өсөлт
1995	4,2	9,7	-8,2
1996	5,8	8,7	-11,1
1997	1,8	0,3	12,1
1998	6,6	7,1	3,6
1999	4,4	6,1	-5,4
2000	-14,5	-16,2	-3,3
2001	-17,1	-21,8	12,7
2002	-10,4	-11,8	-4,3
2003	6,6	58,7	97,6
2004	22,0	29,3	-2,0
2005	8,1	9,6	-0,4
2006	9,0	6,4	26,0
2007	14,9	17,0	3,0
2008	7,2	4,6	23,0
2009	5,7	4,1	14,1
2010	-16,6	-20,2	4,6
2011	2,6	-2,5	21,7

Эх үүсвэр: Монгол улсын ҮСХ-ны 1990-2011 оны жил тутмын статистикийн эмхтгэлийн тоо баримт дээр үндэслэн тооцов. Х-202-232. www.nso.mn

Монгол улсын эдийн засгийн гол үндэс болсон хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийн гол хүчин зүйл нь мал аж ахуйн дэд салбарын өсөлт болж түүний өсөлтөөс ихээхэн хамаарч байна. Тухайлбал 1995 онд хөдөө аж ахуй салбарын өсөлт 4,2% болоход МАА-ын 9,7 хувийн өсөлт нөлөөлсөн бол газар тариалангийн өсөлт -8,2% болж байсан. Тэгвэл 1998 онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 6,6 хувийн өсөлтийн үндэс нь мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 7,1% өсөлт, газар тариалангын 3,6% өсөлтүүд эерэг нөлөө болжээ. Харин 2000 онд ХАА-ийн салбарын өсөлт -14,5% болж унахад мал аж ахуйн салбар -16,2%, газар тариалангийн дэд салбар -3,3% буурч сөргөөр нөлөөлсөн байна. ХАА салбарын уналт 2002 он хүртэл үргэлжилж -10,4% болоход МАА -11,8%, газар тариалангийн дэд салбар -4,3 хувиар буурсан байна. 2003 оноос эхлэн ХАА бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 6,6% өсөлт бий болоход үндсэн 2 салбаруудад хоёулаа өндөр

өсөлт гарч тухайлбал МАА 58,7%, газар тариалангийн дэд салбар 97,6% болон өсч эерэг нөлөө үзүүлжээ.


2003 оноос хойшхи хугацаанд ХАА салбарын үйлдвэрлэл 2010 он хүртэл тогтмол эерэг өсөлттэй гарч байсан боловч 2009-2010 оны зунаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ -20,2% буурч малын тоо хорогдсон нь энэ онд ХАА үйлдвэрлэлийн хэмжээ -16,6% буурахад нөлөөлсөн.

Хэдийгээр 2011 онд МАА салбар -2,5% бууралттай гарсан боловч ХАА салбар бүхэлдээ 2,6% өсөлт гарахад газар тариалангийн салбарт 21,7 хувийн өсөлт гарсан эерэг нөлөө үзүүлсэн байна. Монгол улсын газар зүйн байршил байгаль цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан газар тариалангийн салбарт у, а, т бусад төрлийн хүнсний ногоо тариалж байна.

Ийнхүү манай улсын хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын дотоодын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгдэж байна.

Хөдөө аж ахуйн салбар нь манай улсын эдийн засгийн анхдагч салбар бөгөөд нийгэм, эдийн засгийн хөгжлийн ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жинг зураг 1-ээс харна уу.

Зураг 1-ээс харахад манай улсын ХАА салбарын үйлдвэрлэл 1990-ээд оны эхэнд буюу 1993-1994 онд ДНБ-д 54,8-57,4% эзлэж байгаад харин сүүлийн жилүүдэд энэхүү хэмжээ буурах хандлагатай болж байна. Энэ салбарын хөгжил нь уламжлалт мал аж ахуйн салбарын хөгжилд тулгуурлаж байна. МАА салбар 1990-ээд онуудад ДНБ-ний 40-43 хувийг үйлдвэрлэж байгаа нь манай улсыг мал аж ахуй орон гэдгийг батлаж байна. Харин ДНБ-д эзлэх ХАА салбарын эзлэж байсан орон зайг худалдаа, үйлчилгээ, уул уурхай, олборлох, барилга, холбоо мэдээллийн технологи болон бусад салбарууд эзлэх болжээ. 2010-2011 онд ДНБ-д эзлэх ХАА салбарын хувийн жин 20,8-19,0% болж буурсан байна.




Эх үүсвэр: Монгол улсын ҮСХ-ны 1990-2011 оны жил тутмыг статистикийн эмхтгэлийн тоо баримт дээр үндэслэн тооцов. Х-202-232. www.nso.mn

Газар тариалангийн салбарын ДНБ-д эзлэх хувь 1995-1996 онд 7,2-8,2% байсан бол түүнээс хойш төдийлөн нэмэгдэхгүй байж байгаад 2009 онд 6,5% хүрсэн боловч сүүлийн 2 жилд 2010-2011 онд 5,5-5,1% болж буурах хандлагатай болж байна.

Хөдөө аж ахуйн салбарыг бүтцээр авч үзвэл 2011 оны байдлаар 73,3 хувийг зөвхөн мал аж ахуйн салбарын 26,7 % газар тариалангийн салбар үйлдвэрлэсэн байна. Ийнхүү энэ салбарт нүүдлийн мал аж ахуйн салбар илт давамгайлж байгаа нь Монгол улс нь эрс тэс цаг агаартай учир газар тариалан эрхлэхэд бүтээгдэхүүний өртөг зардал ихтэй байдагтай холбоотой юм.

Зураг 2-оос харахад манай улсын хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуйн салбар үнэмлэхүй давуу байдал буюу 70-80 % эзлэж байна. тухайлбал, 1990 онд ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлд МАА 72,9 % эзэлж байсан бол 1999 он хүртэл малыг малчдад үнэ төлбөргүй хувьчилсны үр дүнд малын тоо өсөж 89,9% эзлэж 17 пунктээр нэмэгдэж байжээ.



Эх үүсвэр: Монгол улсын ҮСХ-ны 1990-2011 оны жил тутамын статистикийн эмхтгэлийн тоо баримт дээр үндэслэн тооцов. Х-202-232. www.nso.mn

Тэгвэл 1999-2002 онд болсон байгалийн хэт хуурайшилт болж малын тэжээл өвс ховордож зуны цагт ган болж, өвөлцас их унаж мал бэлчээрлэх боломжгүй болж зудын улмаас мал ихээхэн хорогдож 2003 онд ХАА-д эзлэх МААны эзлэх хувийн жин 76,9% болж 1990 оны түвшинд эргээд очсон байна. Харин 2004 оноос байгаль цаг агаарын нөхцөл сайжирсны үр дүнд малын тоо нэмэгдэж энэ салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж 2005-2007 онд хамгийн өндөр хувь буюу 86,7% хүрч байлаа. 2011 онд ХАА-д МАА эзлэх хувийн жин 73,3 % болсон нь 2007 оныхоос 13,4 пунктээр буурсан байна. Энэ салбарт нүүдлийн мал аж ахуйн салбар илт давамгайлж байгаа нь Монгол улс нь эрс тэс цаг агаартай учир газар тариалан эрхлэхэд бүтээгдэхүүний өртөг зардал ихтэй байдагтай холбоотой юм. Сүүлийн жилүүдэд байгаль цаг уурын нөхцөл байдал тийм ч их муудаагүй боловч мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурах хандлагатай байна.

Малчид мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ ашигтай зах зээлд гаргаж борлуулах боломж хязгаарлагдмал учир мал аж ахуй эрхэлж амжиргааныхаа эх үүсвэр болгох, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой хүмүүсийн тоо сүүлийн жилүүдэд буурахад нөлөөлж байна. Малчдын дийлэнхи хэсгийнх нь хувьд үйлдвэрлэн бэлтгэж буй бүтээгдэхүүн, түүхий эд нь зөвхөн энгийн нөхөн үйлдвэрлэлээс хэтэрдэггүй, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулсан орлогоороо зөвхөн амиа аргацаах, өрхийнхөө амьжиргааг залгуулах төдий хэмжээнд байгаагаас эрхэлж буй аж ахуйгаа өргөтгөх, эрчимжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, ашиг орлогоо нэмэгдүүлэх, хуримтлал бий болгох боломж тун бага байна.

Нөгөө талаас уул уурхайн салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаатай холбоотой мал аж ахуйн салбараас уул уурхайн салбар руу шилжиж тэнд ажиллах хүмүүсийн тоо нэмэгдэж малчид ажилчин болж хуеирах процесс явагдаж байна.

Газар тариалангийн салбар 1990 он гэхэд манай улсын эдийн засгийн голлох салбарын нэг байж ХАА салбарт газар тариалангийн салбар 27,1% эзлэж манай улс өөрийн үйлдвэрлэсэн буудай үр тариагаар үйлдвэрлэсэн гурилаар дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаад үр тариа экспорлогч орон байлаа. Зах зээлийн харилцаанд шилжихэд хамгийн их хүнд нэрвэгдсэн салбар бол газар тариалангийн салбар бөгөөд 1999 онд ХАА нийт бүтээгдэхүүнд 10,1% эзэлж байлаа. Энэ нь өмнөх социалист нийгмийн үед амжилттай ажиллаж байсан газар тариалангийн САА-ууд хувьчиллын үр дүнд тарж бутарч, машин техникийг хувьчилснаар өмч хөрөнгө тарамдаж нэг хоёр хүний өрхийн түвшинд газар тариалан эрхлэх боломжгүй учир олон тооны газар тариалангын САА-ууд үгүй болоход нөгөөлсөн байна. харин 2000-2003 онд мал аж ахуйн салбар уналтанд орж байхад газар тариалангийн дэд салбар өсөлт бий болж байжээ. Тухайн үеийн Засгийн газраас энэ салбарыг дэмжих талаар чухал арга хэмжээнүүдийг авч тариаланчдад үр тариаг зээлээр олгох болсноор тариалалтын хэмжээ нэмэгдэхэд эерэгээр нөлөөлсөн байна. энэхүү засгийн газрын үйл ажиллагааг дараагийн засгийн газар үргэлжлүүлэн хэрэгжүүлж чадаагүйн улмаас энэ дэд салбар эргээд 2005-2007 онд уналтад орсон.

Монгол Улсын Засгийн газраас 2009 оныг “Үйлдвэржилтийг дэмжих жил”, 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарлаж хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг орчин үеийн хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх, хүн амын гурил, мах, сүү, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах зорилтыг дэвшүүлэн шат дараатай арга хэмжээг авч шийдвэрлэж байна. Тухайлбал, 2009 онд Засгийн газраас “Атарын -3” аянг шинээр эхлүүлж газар тариалангийн үйлдвэрлэлийг бүхий л талаар дэмжих ажлын хүрээнд ОХУ-с 300 сая долларын хөнгөлөлттэй зээл авч тариаланчдад комбайн, ХАА-ын машин техник тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл болон үрийг зээлээр олгож, үйлдвэрлэсэн үр тариаг улс өөртөө худалдаж авах болсоноор сүүлийн 3 жилд тогтмол энэхүү

дэд салбарны үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж ХАА нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жин 2011 онд 26,7% хүрч 1990 оны үеийн хэмжээнээс давсан байна.

Энд дүгнэлт хийхэд өнгөрсөн хугацаанд манай улсын хөдөө аж ахуйн салбарын өсөлт нь мал аж ахуйн салбарын хөгжлөөс маш хамааралтай байж ирсэн ба түүний өсөлт харилцан адилгүй маш тогтворгүй байж иржээ. ХАА салбарын үндсэн 2 салбарууд (МАА, газар тариалан) бие биенийгээ нөхөж нэг нь уналттай байхад нөгөөд нь өсөлт гарч байсан сонирхолтой дүр зураг харагдаж байна. Нөгөө талаас сүүлийн жилүүдэд мал аж ахуйн салбарт уналт бий болж байгаа нь байгаль цаг агаарын нөлөөллөөс илүү малчдын хүсэл сонирхол өөрчлөгдөж субъектив хүчин зүйл нөлөөлөх болж байна. Нэгдүгээрт, байгаль цаг агаарын эрсдлийг бууруулах зорилгоор малчид цөөн тооны хэмжээтэй чанартай малыг өсгөж үржүүлэх шинэ хандлага бий болж байна, хоёрдугаарт, малчид эрсдэл ихтэй мал аж ахуй эрхлэхээсээ илүү хот суурин газарт хөдөлмөр эрхлэх (уул уурхай олборлох салбарт ажиллах) сонирхол нь нэмэгдэж байна.

Мал аж ахуйн салбарт голчлон малчин өрхүүд хувийн өмчийн малаа өсгөх замаар х, я, ү, а, т гэсэн 5 хошуу мал зонхилож байна. Харин сүүлийн жилүүдэд хүнсний чиглэлийн гахай тахиа, шувууны аж ахуй эрхлэх болсон. Тэдгээрийн ихэнхийг махны чиглэлээр үржүүлдэг. Гэхдээ ямааны хувьд түүний н ашигладаг.

Монгол Улс эдийн засаг, нийгмийн шинэ тогтолцоонд шилжиж, мал сүргийг хувьчилснаас хойш малын тоо толгой жил дараалан нэмэгдэж 1999 он гэхэд 33,5 сая толгойд хүрсэн нь манай улсын түүхэнд байгаагүй үзүүлэлт болж байв. Энэ нь малыг малчдад үнэ төлбөргүй хувьчилсны үр дүн юм. Гэвч 1999 оноос манай улсын нийт нутаг дэвсгэрийг бүхэлд нь болон нэлээд хэсэгт олон аймаг, сумдыг хамарсан ган, зуд жил дараалан тохиолдож байснаас үүдэн малын тоо ихээхэн хорогдож, малын тоо 2001 онд огцом буурсан юм.

Харин 2004 оноос эхлэн байгаль цаг уурын нөхцөл бэлчээрийн байдал харьцангуй таатай байсны улмаас малын нийт тоо тогтвортой өсөж 2009 онд 44,0 сая малтай болсон. 2011 онд 36,3 сая малтай болж үүнийг 2009 оныхтой харьцуулахад 17,5% буюу 7,7 сая толгойгоор хорогдсон байна.

Монгол малын сүргийн бүтцийг авч үзвэл 1990 онд нийт малын 2,1% тэмээ, 8,7% адуу, 11,0% үхэр, 58,3% хонь, 19,8, ямаа тус тус эзэлж хонины тоо хамгийн өндөр хувийг эзэлж байжээ. Тэгвэл нийт малын тоонд 2011 онд тэмээ 0,8%, адуу 5,8%, үхэр 6,4%, хонь 43,1%, ямаа 43,9% эзлэх болж сүргийн бүтцэд өөрчлөлт орсон байна.

Энэ 21 жилийн хугацаанд тэмээний хувийн жин 1,2 пунктээр, адууны эзлэх хувийн жин 2,9 пункт, үхрийн хувийн жин 4,6 пункт, хонины хувийн жин 15,2 пунктээр буурсан байхад зөвхөн ямааны эзлэх хувийн жин 24,1 пунктээр нэмэгдсэн байна.

Энэ нь малын сүргийн бүтэц эзлэх бод малын хувийн жин эрс буурч ямааны эзлэх хувийн жин ихээхэн нэмэгдсэн нь малын товарлаг чанар (сүү, мах, арьс шир, ноос, ноолуурыг бүрэн ашиглах) буурч сүргийн бүтцийн тэнцвэрт

байдал алдагдаж байна гэж хэлж болно.

Монголчууд ямааны махыг сэрүүн чанарын гэж үзэн үхэр, хонины махыг ихэвчлэн хүнсэнд хэрэглэхийг эрмэлздэг боловч ямааны тоо ингэж огцом өссөн нь ямааны ноолуурын үнэ дэлхийн зах зээл дээр нэмэгдэх болсноос болж малчид ямааг ихээр тэжээх болсонтой холбоотой юм. Өмнө дурьдсанчлан бид малчин болон түүний өрхийг аж ахуй эрхлэгч гэж үзэх бодит үндэслэлтэй бөгөөд нь манай улсын нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь тийм ч бага биш байгааг зургаас харж болно. Шилжилтийн эхний үед малчин өрхийн нийт өрхөд эзлэх хэмжээ харьцангуй өндөр буюу 1/3 гаруй нь малчин байсан бол энэ үзүүлэлт цаашид буурч байгаа боловч өндөр хэвээрээ байна. 2011 онд нийт өрхөд эзлэх малчин өрхийн хувь 20,4% болсон байна.

Монгол малын тоо

(Мянган толгой)

Он	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд
1990	537,5	2262,0	2848,7	15083,0	5125,7	25856,9
1991	476,0	2259,3	2822,0	14721,0	5249,6	25527,9
1992	415,2	2200,2	2819,2	14657,0	5602,5	25694,1
1993	367,7	2190,3	2730,5	13779,2	6107,0	25174,7
1994	366,1	2408,9	3005,2	13786,6	7241,3	26808,1
1995	367,5	2648,4	3317,1	13718,6	8520,7	28572,3
1996	357,9	2770,5	3476,3	13560,6	9134,8	29300,1
1997	355,4	2893,2	3612,8	14165,6	10265,3	31292,3
1998	356,5	3059,1	3725,8	14694,2	11061,9	32897,5
1999	355,6	3163,5	3824,7	15191,3	11033,9	33568,9
2000	322,9	2660,7	3097,6	13876,4	10269,8	30227,5
2001	285,2	2191,8	2069,6	11937,3	9591,3	26075,3
2002	253,0	1988,9	1884,3	10636,6	9134,8	23897,6
2003	256,7	1968,9	1792,8	10756,4	10652,9	25427,7
2004	256,6	2005,3	1841,6	11686,4	12238,0	28027,9
2005	254,2	2029,1	1963,6	12884,5	13267,4	30398,8
2006	253,5	2114,8	2167,9	14815,1	15451,7	34802,9
2007	260,6	2239,5	2425,8	16990,1	18347,8	40263,8
2008	266,4	2186,9	2503,4	18362,3	19969,4	43288,5
2009	277,1	2221,3	2599,3	19274,7	19651,5	44023,9
2010	269,6	1920,3	2176,0	14480,4	13883,2	32729,5
2011	280,1	2112,9	2339,7	15668,5	15934,6	36335,8

Эх уусвэр: Монгол улсын ҮСХ-ны 1990-2011 оны жил тутмын статистикийн эмхтгэл. Х-Х-202-232. www.nso.mn

Малчин өрхийн тоо 1990-2000 онд 2,6 дахин өсөж байсан бол сүүлийн 2000-2011 онд -19,1% буурсан байна. Энэ үзүүлэлтийг бүсээр нь авч үзвэл 1990-2000 онд баруун бүсийн малчин өрхийн тоо 89,7%, хангайн бүсийн малчин өрхийн тоо 2,7 дахин, төвийн бүс 2,4 дахин, зүүн бүсийн малчин өрхийн тоо 2,4 дахин нэмэгдэж байсан бол Улаанбаатар хотын малчин өрхийн тоо 5,6 дахин нэмэгдсэн байна.

Дүгнэлт хийхэд 1990-2000 оны энэ хугацаанд баруун бүсийн малчин өрхийн тоо хамгийн багаар нэмэгдсэн байхад Улаанбаатар хотод малчин өрхийн тоо хамгийн өндөр нэмэгдсэн байна. Энэ нь нэгдүгээрт, 1990 оны дунд үед цаг агаарын харьцангуй таатай байсан, хоёрдугаарт, Монгол улсын засгийн газраас малыг үнэ төлбөргүй хувьчилсан үр дүнд иргэдийн мал маллах сонирхол нэмэгдэж тэд малчин болж малчин өрхийн тоог нэмэгдүүлэх нөхцөл болсон гэж үзэж байна.

Харин сүүлийн 2000-2011 онд баруун бүсийн малчин өрхийн тоо -1,4%, хангайн бүсийн малчин өрхийн тоо -20,3%, төвийн бүс -11,6%, зүүн бүсийн малчин өрхийн тоо -13,1%, Улаанбаатар хотын малчин өрхийн тоо -13,7% тус тус буурсан байна. Энэхүү бууралт нь малчин өрх ажилчин өрх болж хувирах процесс явагдаж иргэд эдийн засгийн бусад салбарууд руу шилжиж байгаатай холбоотой юм. Манай улсын нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь нилээд өндөр байгаа нь хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд малчдын үүрэг оролцоо чухал байгааг харуулж байна.

Манай улсын малчин өрхийн байршилтыг бүтцээр нь авч 2011 онд нийт малчин өрхийн 26,8% нь баруун бүсэд, 41,1% нь хангайн бүсэд, 19,6% нь төвийн бүсэд 11,2% нь зүүн бүсэд, 1,2% нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Манай улсын нийт хүн амд эзлэх малчдын хувийн жин 1990 онд хамгийн өндөр буюу 22,3% байсан бол энэ үзүүлэлт жил бүр тогтмол буурах хандлагатай байна. тухайлбал, 2000 оны нийт хүн амд эзлэх малчдын хувийн жин 18,1%, 2011г. 13,2% эзлэж байна. Манай улсын хүн амын тоо өсөж байхад малчдын тоо буурсан урвуу хамааралтай байна.

2000 онд улсын нийт малчдын тоог 1995 оныхтой харьцуулахад 2,8 дахин өссөн байхад 2000 оныхоос малчдын тоо 2011 онд -26,2% буурсан байна. Малчдын тооны өөрчлөлтийг бүсээр нь авч үзвэл 1995-2000 онд баруун бүсийн малчдын тоо 2,7 дахин, хангайн бүс 3 дахин, төвийн бүс 2,7 дахин, зүүн бүс 2,7 дахин, Улаанбаатар хотод малчдын тоо 10,5 дахин нэмэгдсэн байхад 2000-2011 онд баруун бүсийн малчдын тоо -32,8%, хангайн бүс -25,4%, төвийн бүс -20,7%, зүүн бүс -21,4%, Улаанбаатар хотод малчдын тоо -8,1% тус тус буурсан байна. дүгнэлт хийхэд малчдын тоо шилжилтийн эхний 10 жилд бүх бүсүүдэд малчдын тоо нэмэгдэж байсан бол сүүлийн 11 жилд бүх бүсүүдэд малчдын тоо буурсан байна. Ялангуяа баруун бүсэд малчдын тоо хамгийн хурдацтай багассан байгаа нь уг бүс нутгаас малчдын хот, суурин газар руу шилжих хөдөлгөөн хамгийн их байдагтай холбоотой юм.

2011 оны байдлаар манай улсад 311,1 мянган нийт малчин өөрийн мал аж ахуйн үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнийг бүс нутгийн байршилтын бүтцээр нь авч үзвэл баруун бүсэд 84,7 мянган малчид буюу нийт малчдын 27,2% амьдарч байхад хангайн бүсэд 126,3 мянган малчин буюу нийт малчны 40,6% нь, төвийн бүсэд 59,8 мянган малчин амьдарч нийт малчны 19,2% нь, зүүн бүсэд 35,5 мянган малчин амьдарч нийт малчдын 11,4% нь, Улаанбаатар хотод 4,7 мянган малчин амьдарч, нийт малчны 1,5% нь ногдож байна.

Эндээс дүгнэлт хийхэд хангайн бүс нь малчдын тоогоор тэргүүлж, дараа нь хэдийгээр хот руу чиглэсэн нүүдэл их байгаа боловч баруун бүс малчдын тоогоор хоёрдугаарт орж байна. Зүүн бүс хамгийн цөөхөн малчинтай бөгөөд Улаанбаатар хотын ойролцоох газар нутагт нийт малчдын дөнгөж 1,5% амьдарч байна.

Малчдыг насны бүлгээр нь авч үзвэл 2011 оны байдлаар нийт малчдын 45,1% нь 16-35 настай, 46% нь 36-55 настай, 12,5 % нь 56-61 настай байна. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт залуучууд мал маллах сонирхолтой болж малчид залуужиж байгаа нь сайшаалтай боловч тэдэнд мал маллах, тэжээж арчлах, ялангуяа мал сүргийг отроор таргалуулах, бэлчээр, усаа зөв сонгож ашиглах, байгалийн гамшгаас малаа хамгаалах нөөц бүрдүүлэх, бэлтгэл хангах туршлага, чадвар дутагдах явдал байсаар байна.

Төр засгийн газраас малчдыг хүн амын орлогын албан гатвар болон бэлчээрийн газрын төлбөрөөс чөлөөлж байгаа боловч малчдын бодит орлого, хуримтлалын хэмжээ нэмэгдэхгүй төрийн дэмжлэг тусалцааны үр дүн бодитой харагдахгүй байна.

Гэсэн хэдий ч манай улсын төр засгаас мал аж ахуйн хоршооны үйл ажиллагааг дэмжиж хоршоогоор дамжуулан мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, малчид, хөдөөгийн хүн амын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх ажлын байрыг нэмэгдүүлэх асуудалд онцлон анхаарсаар байна. Хоршоог хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн нэгж гэж үзэж, аймаг, сумдад загвар хоршоо байгуулах, ялангуяа ХХААХҮЯ-ны зүгээс олгож буй дэмжлэгт хоршоодыг түлхүү хамруулах бодлого баримталж байна. Хөдөө орон нутагт түүхий эд бэлтгэл, жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр ажиллаж байгаа хоршоодын үйл ажиллагааг дэмжих чиглэлийг баримталж байна.

Гэвч манай улсын малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч малчдын хоорондын хамтын ажиллагааг зохицуулах нэгдсэн тогтолцоо байхгүй, малчин түүхий эдийн зах зээлийн үнэ ханшийн талаарх мэдээ, мэдээллийг шуурхай авч чадахгүй, зах зээлийн харилцаанд суралцах боломж дутмаг байдаг зэргээс шалтгаалан тэд түүхий эдээ борлуулснаас олох ашиг, орлого бага байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр дүн малчдын аж ахуйгаа эрхлэх мэдлэг, туршлага, бизнес сэтгэлгээнээс хамаарч байна. Ялангуяа мал сүргийг өсгөн үржүүлэх, ашиг шимийг нь сайжруулан ашиглахад хүний хүчин зүйлс шийдвэрлэх ач холбогдолтой билээ.

Төрийн зүгээс малчид мал аж ахуйн материаллаг баазаа бэхжүүлэх, бэлчээр нутгаа зохистой эзэмших чиглэлээр туршлага солилцох тогтолцоог бүрдүүлэх, мал аж ахуйн түүхий эдийг анхан шатны боловсруулалт хийх (малын арьс ширийг давслах, хадгалах) технологийн туслалцаа үзүүлэх, малчдыг үйлдвэрлэгчтэй нягт хамтран ажиллах тогтолцоог бий болгоход анхаарах шаардлага гарч байна.

Монгол Улсын хураан авсан ургацын хэмжээ

(мянган тн)

Он	Үр тариа	Улаан буудай	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал
1990	718,3	596,2	131,1	41,7	527,1
1995	261,4	256,7	52	27,3	18,7
1996	220,1	215,3	46	23,8	18,8
1997	240,4	237,7	54,2	34	14,3
1998	194,9	191,8	65,2	45,7	14,7
1999	169,5	166,7	63,8	39	5,3
2000	142,1	138,7	58,9	44	4,1
2001	142,2	138,7	58	44,5	2,7
2002	125,9	123,1	51,9	59,6	3,5
2003	165	160,4	78,7	59,6	8,4
2004	138,5	135,6	80,2	49,2	9,6
2005	75,5	73,5	82,8	64,2	8,3
2006	138,6	127,8	109,1	70,4	10,2
2007	114,8	109,6	114,5	76,4	14,1
2008	212,9	209,8	134,8	78,6	19,9
2009	391,7	388,1	151,2	78,0	10,4
2010	355,1	345,5	168	82,3	34,8
2011	446,1	435,9	201,6	99	40,4

Эх үүсвэр: Монгол улсын ҮСХ-ны 1990-2011оны жил тутмын статистикийн эмхтгэл. Х-202-232. www.nso.mn

Манай улс 1990 онд 718,3 мянган тн үр тариа хурааж авч үүний 83,0 % нь улаан буудай тариалж хураан авч байжээ. Энэ хэмжээг 2000 оны 142,1 мянган тн. хураасан үр тарианы хэмжээтэй харьцуулахад 80,2%, 2011 онд хураасан 446,1 мянган тн үр тарианы хэмжээтэй харьцуулахад 37,9% тус тус буурсан байна. Харин сүүлийн 11 жилд хураасан ургацын хэмжээ жил тутам нэмэгдэж байсан ба 2000 онд хураасан ургацын хэмжээг 2011 оныхтой харьцуулахад үр тариа 3,1 дахин нэмэгдсэн байна. Манай улс 2004 оноос эхлэн арвай, овъёос тариалж эхэлсэн ба үр тариаг бүтцээр нь авч үзвэл улаан буудай ихэнх хувийг буюу 97,7%, арвай 1,0%, овъёос 0,9% эзэлж байна.

Хүснэгтээс харахад хураан авсан төмсний хувьд 1990 онд 131,1 мянган тн. төмс хурааж авч байсан бол 2000 онд хураан авсан төмсний хэмжээ 55,1% буурсан байхад 2011 онд 3,4 дахин нэмэгдсэн байна. Тэгвэл хүнсний ногоо 1990-2000 онд 5,5%, 2000-2011 онд 2,2 дахин нэмэгдсэн байна. Хураан авсан тэжээлийн ургамлын хэмжээ 1990-2000 онд 99,2% багасаж байсан бол 2000-2011 онд 9,9 дахин нэмэгдсэн байна.

Дүгнэх хэлэхэд манай улсын хураан авсан ургацын хэмжээ бүх төрлөөрөө 1990-2000 онд огцом буурсан бол сүүлийн 2000-2011 онд нэмэгдсэн байдалтай байна. Энэ нь нэгдүгээрт, байгаль цаг агаарын байдал харьцангуй тааламжтай байсан, хоёрдугаарт, Монгол улсын Засгийн газраас газар тариаланг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж “Атрын 3 дахь аян” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэнтэй холбоотой гэж үзэж байна. Гэсэн хэдий ч 1990 ойд хурааж авч байсан ургацын хэмжээнд хүрч чадахгүй байна.

Зүүн бүсэд “Атрын 3 дахь аян”-ны үргэлжлэл болох “Халх гол” төслийг хэрэгжүүлж эхэлснээр газар тариалангийн салбарт ч мөн өсөлт гарч байна. 2011 оны хувьд зуншлага, өвөлжилтийн үеэр цаг агаарын байдал харьцангуй таатай байсан учир хураасан үр тарианы хэмжээ бүх төрлөөр нэмэгдсэн байна.

Байгаль цаг уурын тааламжтай нөхцлөөс шалтгаалан 1 га талбайгаас хураах ургалын хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж байна. Тухайлбал 2009 онд 1 га талбайгаас хураасан үр тарианы хэмжээ хамгийн өндөр буюу 15,5 центнерт хүрсэн нь манай улсын хувьд хамгийн өндөр амжилт байлаа. 2011 онд 1 га талбайгаас хураасан үр тарианы хэмжээ 14,9 центнерт хүрсэн нь өмнөх 2010 оныхоос 1,2 центнерээр нэмэгдсэн байна. Үүнд 2011 онд 1 га талбайгаас хураасан улаан буудай 15 центнерт хүрч 2010 оныхоос 1,2 центнер, арвай 5,7 центнер, төмс 9,5 центнерээр нэмэгдсэн байна.

Дүгнэлт хөдөө аж ахуйн салбар нь манай улсын эдийн засгийн хөгжил чухал үүрэг гүйцэтгэдэг анхдагч салбар бөгөөд 1990 оноос хойшхи хугацаанд ХАА салбарын байр суурь буурах хандлагатай байна. Энэхүү салбар нь байгаль цаг агаарын хүчин зүйлээс ихээхэн хамааралтайгаас гадна мал аж ахуй салбарыг хөгжүүлэх талаар төрөөс үзүүлж байгаа татвар болон бусад төлбөрийн дэмжлэг бодитой үр дүнгээ өгөхгүй байна гэж үзэж байна. Энэ нь мал аж ахуй салбар нь уламжлалын дагуу эрчимжээгүй хөдөлмөрийн бүтээмж багатай холбоотой юм. Мал аж ахуйн салбарт орчин үеийн мал маллагааны технологи нэврэх нь

туйлын хойрго, малын товарлаг шинж чанар маш муу байна. Өөрөөр хэлбэл 1 малаас авах ашиг шимийн хэмжээ маш бага байна.

Газар тариалангийн салбарын хөгжлийг сэргээх талаар төр засгаас ихээхэн анхаарч байгаа боловч энэ салбар нь 1990 оны өмнөх түвшинд хараахан хүч чадаагүй бөгөөд байгалийн хүчин зүйлээс шалтгаалсан хэвээрээ байна.

Монгол Улсын 1 га талбайгаас хураасан ургацын хэмжээ

(центнер)

Он	Үр тариа	Улаан буудай	Арвай	Овьёос	Төмс
1990	11	11,2	10,1	10,4	107,7
1995	7,3	7,4	7,7	0,6	83,5
1996	6,6	6,6	7,6	1,0	66,4
1997	7,6	7,6	6,2	0,5	82,3
1998	6,3	6,4	5,5	2,7	80,3
1999	6,1	6,1	5,9	1,5	72,8
2000	7,3	7,2	8,7	2,1	74,7
2001	7,1	7,2	5,6	4,6	65,6
2002	5,7	5,9	8,2	3,9	56,4
2003	8	7,9	12,5	11,4	93,4
2004	8	8,1	6,1	6,8	88,3
2005	4,7	4,8	6	6,9	84,8
2006	11	10,8	36,3	14,8	101,7
2007	9,4	9,4	13,8	8,4	99,9
2008	13,8	14	10,5	11	109,6
2009	15,5	15,6	12,6	10,7	111,8
2010	13,7	13,8	9	12,8	121,6
2011	14,9	15	14,7	11,5	131,1

Эх үүсвэр: Монгол улсын ҮСХ-ны 1990-2011 оны жил тутмын статистикийн эмхтгэл. Х-202-232. www.nso.mn

Иймд хөдөө аж ахуйг эрчимжүүлэх, малын үүлдэр угаас сайжруулах, нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, мах сүүний чиглэлийн малыг илүү ихээр үржүүлэх, мал, амьтаны тэжээл үйлдвэрлэх үйлдвэрүүдийг бүхий талаар төр засгаас дэмжих, малчин хүн-үйлдвэрлэгч хоёрын хоорондын малын түүхий эд бэлтгэх хангах, хадгалах тогтолцоог шинээр бий болгох шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Кантильон Ричард. “Опыт о природе торговли вообще”. (Впервые опубликовано в 1755)
2. Адам Смит “Исследование о природе и причинах богатства народов” 1776г.
3. Жан Батист Сэй “Трактат Политической экономии” 1803г.
4. Й «Капитализм, социализм и демократия» Joseph Alois Schumpeter: «Capitalism, Socialism and Democracy», 1942
5. Лапуста М.Г. Предпринимательство: Учебник.- М.:ИНФРА-М, 2009.- 608 с. – (Высшее образование). Стр.21.
6. Монгол улсын Засгийн газрын “Атрын-III Аян” хөтөлбөр, 2009 он.
7. Монгол улсын Засгийн газрын “Монгол улсыг үйлдвэржүүлэх” хөтөлбөр, 2009 он.
8. Монгол улсын ҮСХ-ны жил тутамын статистикийн эмхтгэл (1990-2011он).

Summary: in this article affected the role of agriculture in economic development of Mongolia, the structure of the rural economy and its growth, factors affecting the development of agriculture, growth in the number of livestock, herds-mans share in the total population of the country, the trend of the development of agriculture